



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/138

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран сумын Засаг дарга нар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын холбогдох мэргэжилтнүүдийг мал үржлийн болон газар тариалангийн чиглэлээр туршлага судлах арга хэмжээг Дархан-Уул, Төв аймагт 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 04 дүгээр сарын 07-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Туршлага судлах арга хэмжээний хөтөлбөрийг батлуулж, үр дүнтэй зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-д даалгасугай.

3. Тус арга хэмжээнд бэлтгэл ажлыг сайтар хангаж, нэгдсэн зохион байгуулалтай оролцохыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Туршлага судлах арга хэмжээнд шаардагдах унаа, шатахууны зардал нийт 1,882,500 (нэг сая найман зуун наян хоёр мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0295

D:My Doc. Zahiramj. Zasag darga